



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/32

Жаргалтхаан


Хорио цээр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.2.2, 15.2.3, 15.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цой” ХХК-ны үржүүлгийн зориулалттай Герефорд үүлдрийн эр үхэр 20 толгой, бух 3 толгой, үнээ 41 толгой, гунж 11 толгой, тугал 31 толгой, нялх энэ жил төрсөн тугал 11 толгой, нийт 117 толгой үхрийг Оросын Холбооны Улсаас импортлон, 7-14 хоногийн зайтайгаар, 3-4 удаагийн давтамжтайгаар зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн оруулж ирэх тул Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын 3-р багийн нутаг, Хэрмийн тал 01 хаягт байрлах, “Эбэг” ХХК-ны эзэмшлийн үтрэмийн зориулалттай, 5,0 га газарт улсын хилээр орж ирсэн өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэмд оруулсугай.

2. Хорио цээрийн дэглэмийн хугацаанд тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл, үхрийн байр, хашаа саравчинд халдваргүйтгэл хийх, импортоор ирсэн үхрээс холбогдох зааврын дагуу дээж авч, мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, холбогдох мэдээ тайланг нэгтгэн танилцуулахыг “Мөнхбадрах зоргол” ХХК-ны малын их эмч (Б.Уранцэцэг) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ